Хяргааны хэм тогтоох
Монгол улсын нэгдсэн
2019 оны 03 сарын 05
426Т

# МОНГОЛ УЛСЫН
# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 21 өдөр  Дугаар А/16  Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уурхай, уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журмыг нэгдүгээр, Уурхай, уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардлагатай бичиг баримтын бүрдлийг хоёрдугаар, Баяжуулах, боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардлагатай бичиг баримтын бүрдлийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцүүлэн үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлтгэл ажлаа хангасан уурхай, уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах асуудлыг зохион байгуулах, комиссын төлөөллийг журмын дагуу бүрдүүлэх, комиссын даргыг тухай бүр томилон ажиллуулахыг Геологи, Уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Мөнхтөрд даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Үйлдвэр, худалдааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 291 дүгээр тушаал, Уул уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 32 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Д.СУМЪЯАБАЗАР

Бүртгэлийн дугаар 34
МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД
ХУУЛБАР ҮНЭН
Ш. Ураншинж
2019 02 25

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2019 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн
4/16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг
ашиглалтад хүлээн авах журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасныг үндэслэн холбогдох болон бусад хууль, дүрэм, журам, заавар, стандартын шаардлага, тухайн орд газрыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд нийцүүлэн уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авахад оршино.

1.2. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын өмнөх бэлтгэл ажлыг бүрэн хангасан аж ахуйн нэгж (цаашид "компани" гэх) нь Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан хүсэлт гаргаж Комисс (цаашид "Комисс" гэх) томилуулах, томилогдсон Комисс уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрт ажиллахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Комиссын зохион байгуулалт, бүрэлдэхүүн

2.1. Комиссыг дараахь байдлаар зохион байгуулна. Үүнд:

2.1.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг түшиглэн барьж байгуулсан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний томилсон Комисс хүлээн авна.

2.1.2. Энэхүү журмын 2.1.1-т зааснаас бусад Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан удирдамжийн дагуу Комисс хүлээн авна.

2.1.3. Улсын Комиссын дарга нь Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын газар, хэлтсийн дарга болон ахлах мэргэжилтэн байна.

2.2. Комиссын бүрэлдэхүүн сондгой тооны 5-9 хүртэлх хүний гишүүнтэй байх ба ажил үүрэг, чиглэлийн дагуу дараах яам, агентлагийн төлөөллийг оролцуулсан байна. Үүнд:

- Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;
- Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
- Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
- Орон нутгийн төлөөлөл буюу сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар. (шаардлагатай тохиолдолд)

34

Ш. Гүрэнчимэг
19 02 сарын 25-ний өдөр

2.3. Тухайн уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн онцлогийг харгалзан тухайн комиссын бүрэлдэхүүнд шаардлагатай тохиолдолд Дэд бүтэц (зам, тээвэр, эрчим хүч, барилга, хот байгуулалт)-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

2.4. Комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар бүрэлдэхүүнд багтаж ажиллаж чадахгүй тохиодолд тухайн чиг үүргийг хариуцсан байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

## Гурав. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах Комиссын эрх, үүрэг

3.1. Комисс хурлын дэгийг өөрөө тогтооно. Комиссын дарга дэгийг сахиулж, дэгийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах, хурлыг хаалттай хийх, зэрэг хэлэлцэх асуудлын дараалыг тогтооно.

3.2. Комиссын гишүүдийн олонхи уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан гэж үзвэл акт үйлдэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж өгнө.

3.3. Комиссын гишүүдийн олонхи тухайн уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй гэж үзвэл компанид хугацаатай албан даалгавар өгч, албан даалгаврын хэрэгжилтийн тайланг албан ёсоор ирүүлсэн тохиолдолд акт үйлдэж болно.

3.4. Комиссын гаргасан дүгнэлттэй зарчмын зөрүүтэй саналтай гишүүд саналаа хурлын тэмдэглэлд тусгайлан тэмдэглүүлж болно.

3.5. Комисс нь Ашигт малтмалын тухай болон Монгол улсад мөрдөгдөж буй бусад хууль, дүрэм, журам, заавар, стандартын шаардлага, тухайн орд газрыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл зэрэгтэй танилцаж, хянан үзэхийн зэрэгцээ дор дурьдсан баримт бичиг, бүтээн байгуулалтын ажлуудтай танилцаж, шалгана. Үүнд:

3.5.1. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн талбай, хэсэг, цех, шат дамжлагын барилга байгууламж, тоног төхөөрөмж, тусгай зөвшөөрлийн талбайн шав тэмдэгт газар дээр нь хяналт хийж техник, эдийн засгийн үндэслэл болон бусад зураг төслийн дагуу байгуулсан бүтээн байгуулалт, төсөлд тусгагдсан техник, технологи, тоног төхөөрөмж, машин механизмуудыг ажиллуулж байгаа эсэх;

3.5.2. Ажилтнуудын ажлын байр, ажиллах нөхцөл, ахуйн байр, технологийн болон унд ахуйн усан хангамж, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэр, галын аюулгүй байдал, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм, журмын шаардлагад нийцэж буй эсэх;

3.5.3. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь "Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм", "Хүдрийн далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм" болон уурхай, уулын үйлдвэрийн онцлог, технологи, шат дамжлагад холбогдох бусад хууль, дүрэм, журмын шаардлагад нийцэж байгаа эсэх;

34

Ц. Эрдэнэжаргал
19 02 25

3.5.4. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах, тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын түгээх байр болон тэсэлгээний үйл ажиллагааны бэлтгэл ажил "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-д нийцэж байгаа эсэх;

3.6. Комиссын бүх гишүүдийн гарын үсэг зурж баталгаажуулсан акт нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх, ашиглалтад хүлээн авсан эрх зүйн баримт бичиг болно.

## Дөрөв. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээлгэн өгөх компанийн эрх, үүрэг

4.1. Компани нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээлгэн өгөх хүсэлтээ Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүргүүлэх ба өөрийн эзэмшлийн уурхай болон барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.

4.2. Компани нь Комиссын нарийн бичгийн даргад энэхүү журмын хавсралтад заасан бүрдлийг Комисс ажиллахаас ажлын 5 хоногийн өмнө урьдчилж хянуулсан байна.

4.3. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх компани нь Комиссын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдлыг хангана.

4.4. Баяжуулах үйлдвэрийн металл авалт, болон гарц, хаягдлын сангийн хоргүйжүүлэлт, далд уурхайн агааржуулалт, агаарын бохирдолт зэргийг мэргэжлийн байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байх ба барилга, байгууламж, эрчим хүчний шугам сүлжээ, дэд станцад эрх бүхий байгууллагын акт, баримтыг бүрдүүлсэн байна.

4.5. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах Комиссын томилолтын зардлыг хүсэлт гаргасан тухайн компани хариуцна.

## Тав. Бусад

5.1. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авахтай холбоотой гарах маргаантай асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

--- o O o ---

Бүртгэлийн дугаар 34
МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар эх сурвалжтай адилтгах гэрчилгээ
Ц. Цэнгэлмаа
2019 оны 02 сарын 25 өдөр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2019 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
А/16 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардлагатай бичиг баримтын бүрдэл

1. Орд газрыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл
2. Байгаль орчин нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
3. Тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө
4. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээ
5. Олборлолтын журнал (ашиглалтын үеийн геологи, маркшейдерийн хэмжилт, сар, улирлын гүйцэтгэлийн мэдээ гэх мэт)
6. Төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын зардлыг нөхөн төлөх гэрээ, төлбөрийн баримт
7. Технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтын тайлан, баяжуулалтын алдагдал хаягдлыг өөрсдөө болон хяналтын байгууллагын тогтоосон тайлан, хяналтын байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
8. Уурхайн эдэлбэрийн шав тавиулсан тухай акт
9. Тэсэлгээний ажил явуулах зөвшөөрөл (Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт)
10. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн менежментийн төлөвлөгөө
11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын 50%-ийг барьцаалсан баримт
12. Газар, ус ашиглах гэрээ болон төлбөр төлсөн тухай баримт
13. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа
14. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
15. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтын бүртгэл
16. Ажиллах хүчний судалгаа, тэдгээртэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ (тухайн орон нутгаас ажиллаж буй ажилчдын ажлын байрны судалгаа)
17. Нөөц бодсон геологийн дэвсгэр зураг
18. Мэргэжлийн хяналтын байгууллагаас урьд өмнө тавьсан албан шаардлага, түүний хэрэгжилт

--ооООо--

Бүртгэлийн дугаар 34
МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар эх гаргасан ажилтны гарын үсэг
И. Ганчимэг
2019 оны 02 сарын 25-ны өдөр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2019 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн
А/16 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Баяжуулах, боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад
шаардлагатай бичиг баримтын бүрдэл

1. Үйлдвэр ашиглах техник, эдийн засгийн үндэслэл
2. Тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө
3. Баяжуулах, боловсруулах, үйлдвэрийн баталгаажуулсан зураг төсөл
4. Үйлдвэрийн барилга байгууламжийг Улсын комисст хүлээлгэн өгсөн акт
5. Хаягдлын аж ахуйн далангийн баталгаажуулсан зураг төсөл
6. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн журнал (сар, улирлын гүйцэтгэл)
7. Байгаль орчин нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
8. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээ
9. Технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтын тайлан, баяжуулалтын алдагдал хаягдлыг өөрсдөө болон хяналтын байгууллагын тогтоосон тайлан, хяналтын байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
10. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн менежментийн төлөвлөгөө
11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын 50%-ийг барьцаалсан баримт
12. Газар, ус ашиглах гэрээ болон төлбөр төлсөн тухай баримт
13. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа
14. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
15. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтын бүртгэл
16. Ажиллах хүчний судалгаа, тэдгээртэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ (тухайн орон нутгаас ажиллаж буй ажилчдын ажлын байрны судалгаа)
17. Ашигт малтмалын хүдэр, баяжмал худалдан авах гэрээ
18. Мэргэжлийн хяналтын байгууллагаас урьд өмнө тавьсан албан шаардлага, түүний хэрэгжилт

Бүртгэлийн дугаар 34
МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар эх хувьтай адилтгах гарын үсэг
Ц. Цэрэнцэдэв
2019 оны 02 сарын 25-ны өдөр

--ooOoo--